

# Цөлийн Нарны Эрчим Хүч Төсөл

Байрлал: Монгол Улс  
Төслийн дугаар: 48576

Бизнесийн салбар: Цахилгаан, эрчим хүч

Төрөл: Хувийн

Байгаль орчны ангилал: В

ТУЗ-өөр хэлэлцүүлэх өдөр: 2018 оны 2-р сарын 14

Төлөв: Хөрөнгө оруулалтын хорооны хурлын эцсийн зөвшөөрлийг авсан, ТУЗ-ийн зөвшөөрөл хүлээгдэж байна

Англи хэл дээрх төслийн товч танилцуулгыг нийтэлсэн өдөр: 2017 оны 12-р сарын 21-нд танилцуулагдсан

## Төслийн танилцуулга

Улаанбаатар хотоос зүүн урагш 450 км-ийн зайд, Говьд байрлах 30МВт фото элементийн (PV) нарны цахилгаан станц барьж байгуулах, ажиллуулах, хөгжүүлэх зорилгоор Дезерт Солар Пауэр Вуан ХХК буюу (цаашид Компани гэх)-д олгох 30.7 сая ам доллар хүртэлх хязгаарлагдмал баталгаат, тэргүүн ээлжид эргэн төлөх нөхцөлтэй А/В ангиллын зээл.

## Төслийн зорилго

Төсөл нь Монгол Улсын нүүрсний эрчим хүчний хамаарлыг бууруулах, өсөн нэмэгдэж буй цахилгаан эрчим хүчний эрэлт хэрэгцээг хангах, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг 2020 онд 20%, 2030 онд 30%-д хүргэх Монгол улсын стратеги зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Мөн уг төсөл Монгол улсын эрчим хүчний салбар дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой.

## Шилжилтийн нөлөө

Төсөл нь нүүрснээс бусад эрчим хүчний эх үүсвэрүүдийг бий болгож, нүүрс төрөгчийн хийн (CO<sub>2</sub>) ялгаруулалтыг бууруулах замаар шилжилтийн (чөлөөт зах зээлийг хөгжүүлэх) нөлөө үзүүлэх болно. Төсөл нь ЕСБХБ-ны Ногоон эдийн засгийн шилжилтийн (НЭЗШ) зарчимд нийцэж байгаа болно.

## Харилцагчийн мэдээлэл

### Дезерт Солар Пауэр Вуан ХХК

Зээлдэгч нь Төслийг боловсруулах, бүтээн байгуулах, үйл ажиллагааг нь явуулах зорилгоор Монгол Улсад хуулийн дагуу байгуулагдсан тусгай зорилго бүхий

хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Уг Компанийг Tucher Group GmbH болон сэргээгдэх эрчим хүч, бусад чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг Юнайтед Грийн Групп хамтран эзэмшдэг.

## ЕСБХБ-ны олгох санхүүжилт

10,206,750.00 ам.доллар

ЕСБХБ Компанид нийтдээ нь 30.7 сая ам доллар хүртэлх хязгаарлагдмал баталгаат А/В ангиллын зээлийг олгохоор хэлэлцэгдэж байна.

## Төслийн нийт өртөг

47,520,250.00 ам.доллар

Төслийн нийт өртөг 47.5 сая ам доллар.

## Байгаль Орчин, Нийгмийн Асуудлын тухай

Байгаль орчны нөлөөллийн ангилал “В” (2014 ESP). Байгаль орчин аялал жуулчлалын яам Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) 2013 онд баталсан бөгөөд 2018 онд төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр тооцоолж байна. Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан бие даасан зөвлөх нь ЕСБХБ-ны шаардлагуудад нийцүүлэн төслийг хянан дүгнэсэн бөгөөд уг төслийг дотоодын болон Европын холбогдох хууль тогтоомж, ЕСБХБ-аас тавьж буй Гүйцэтгэлийн шаардлагуудад нийцүүлэн боловсруулсан болохыг баталсан. БОННУ, Холбогдох талуудын оролцооны төлөвлөгөө, Техникийн бус товч хураангуй, Байгаль орчин, Нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөг (БОНУАТ) Банкны болон Компанийн веб сайтуудад байрлуулан мэдээлж байна. Төсөл нь 100% НЭЗШ-д чиглэсэн байх бөгөөд жилд ойролцоогоор 47,606 TCO<sub>2e</sub> хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулна гэж тооцоолж байна.

30МВт фото элементийн (PV) нарны цахилгаан станцтай холбоотой гарах нөлөөлөл нь тухайн газар нутгаар хязгаарлагддаг, аливаа саад бэрхшээлийг талбай дээр нь хяналтад авч, арилгах арга хэмжээ авах боломжтой гэж үзсэн. Төсөл нь аливаа биологийн төрөл зүйл, соёлын өв зэрэгт сөргөөр нөлөөлөхгүй мөн нүүлгэн шилжүүлэлттэй хийх шаардлага үүсгэхгүй. Монгол улсын хууль тогтоомжийн дагуу БОННУ-г олон нийтээр хэлэлцүүлж зөвлөлдөх шаардлагагүй боловч ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлагын 10-аар заалтын дагуу Холбогдох талуудын оролцооны төлөвлөгөө боловсруулсан болно. БОНУАТ-г Компанитай харилцан зөвшилцсөн ба үүнд: (i) бүтээн байгуулалтын ажлын үеийн Байгаль орчин, Нийгмийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, (ii) төслийн бүтээн байгуулалтын өмнө биологийн төрөл зүйлийн судалгааг Төслийн талбай болон цахилгаан дамжуулах агаарын шугамын коридорын дагуу хийх. Шаардлагатай бол БОННУ-д тусгасан хор хөнөөлийг бууруулах арга хэмжээг боловсронгуй болгох; (iii)

хэрэв барилгын ажлын явцад соёлын өвтэй холбоотой зүйл илрэх тохиолдолд археологийн олдворын журам боловсруулах, хэрэгжүүлэх; (iv) барилгын ажил гүйцэтгэх болон ашиглалтын үйл ажиллагааны явцад Холбогдох талуудын оролцооны төлөвлөгөөг шинэчлэх, хэрэгжүүлэх зэргийг тусгасан байна. Түүнчлэн, барилгын ажил/үйл ажиллагааны явцад Компани нь төслийн стандарт болон түүний БОНУАТ-ний шаардлагуудыг баримталж буй эсэхийг харуулсан тайлангуудыг ЕСБХБ-д тогтмол танилцуулах үүрэгтэй.

Уг төсөл нь ЕСБХБ-ны шаардлагуудад нийцсэн байгаа эсэхийг хараат бус байгаль орчин, нийгмийн зөвлөх хянасан бөгөөд төслийн бүтэц нь Европын холбогдох хууль тогтоомж, ЕСБХБ-аас тавих Гүйцэтгэлийн шаардлагуудад нийцсэн болохыг баталсан.

Төслийн [БОННУ](#), [ООТ](#), [Техникийн бус товч хураангуй](#), [Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөг](#) ЕСБХБ болон [Компанийн веб хуудсанд](#) байрлуулсан болно.

## Техникийн хамтын ажиллагаа

Үгүй.

## Компанийн мэдээлэл

Klaus Merz

[klm@unitedgreen.com](mailto:klm@unitedgreen.com)

+44 7824 508288

[www.unitedgreen.com](http://www.unitedgreen.com)

P40, 2 Lansdowne Row

Mayfair W1J 6HL

United Kingdom

## Бизнесийн боломжууд

Бизнесийн боломж эсхүл төслийн хангамж үйлчилгээний талаар Компанитай шууд холбоо барина уу.

Төрийн байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлж буй төслүүдтэй холбоотой бизнесийн боломжуудын талаарх мэдээллийг [ЕСБХБ-ны хангамж үйлчилгээний](#) багийн цахим хуудсаар зочилж авна уу.

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: [procurement@ebrd.com](mailto:procurement@ebrd.com)

## Ерөнхий лавлагаа

Хангамж үйлчилгээтэй холбоогүй ЕСБХБ-ны төслийн лавлагаа:

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудан: [projectenquiries@ebrd.com](mailto:projectenquiries@ebrd.com)

## Олон нийтийн мэдээллийн бодлого (ОНМБ)

ОНМБ нь ЕСБХБ мэдээллийг хэрхэн мэдээлэх, түүний оролцогчидтой хэрхэн зөвлөлдөх талаар тусгасан байдаг. Энэ нь холбогдох стратеги, бодлого, үйл ажиллагааны талаар илүү сайн мэдлэг, мэдээлэл, ойлголт авахад тустай. Олон нийтийн хэсгийн зөвлөлийн тайланг хэрхэн хүсэх талаар Олон нийтийн мэдээллийн бодлого хуудаснаас орж авна уу. [ОНМБ](#)

## Төслийн гомдлын механизм (ТГМ)

[Төслийн гомдлын механизм](#) нь гэдэг ЕСБХБ-ны хариуцлага тооцох механизм юм. Энэхүү механизм нь ЕСБХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүд нь байгаль орчин/нийгэмд хор хөнөөл бий болгосон аль эсвэл хор хөнөөл бий болгох магадлалтай гэх хувь хүн болон аливаа байгууллагуудын зүгээс гаргасан гомдлуудыг хараат бус байдлаар дүгнэх боломжийг олгодог юм.

Гомдол хэрхэн гаргах талаарх мэдээллийг [Төслийн гомдлын механизм](#) хуудаснаас авна уу. ТГМ-ийн ажилтан ([pcm@ebrd.com](mailto:pcm@ebrd.com)) ТГМ-ийн дүрмийн дагуу гомдол гаргах, бүртгэлийн болон бусад шалгуурын талаар гарч болох аливаа асуултад хариулна.